

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2000 онд баталснаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх хуульчлан зохицуулсан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд шинэчлэн найруулж баталснаар төсвийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагааг захиалагч бие даан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт хариуцлагыг бүрэн хүлээх төвлөрсөн бус тогтолцоонд шилжсэн байна.

Нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжин өөрчлөгдөж, техник, технологийн дэвшлийг нийгмийн харилцаанд өргөнөөр ашиглах шаардлага үүссэн энэ үед худалдан авах ажиллагаа ч шинэ шатанд гарах шаардлагатай болсон. Хүний эрх, эрх зүйн суурь зарчимд тулгуурласан, өрсөлдөөн, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчин үеийн хөгжлийн чиг хандлага болох хүний оролцоог бууруулсан худалдан авах ажиллагааг зохион байгуулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох цаг үеийн шаардлагад үндэслэн 2023 онд Монгол Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж, 2024 оноос мөрдөж эхэлсэн.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан дэвшилтэд технологи, хиймэл оюуныг ашиглах, хувийн хэвшлийг дэмжих зохицуулалтыг бүрэн гүйцэт тусгаагүй нь хуулийн зорилго биелэх нөхцөлийг алдагдуулж орчин цагийн шаардлагаар үүссэн цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээ нь захиалагч байгууллагын хэрэгцээг бүрэн хангахгүй мөн цар хүрээ өндөр, олон төрлийн бараа, ажил, үйлчилгээг нэгтгэн нэг этгээдээр гүйцэтгүүлэх, гэрээ байгуулах тендер шалгаруулалт зохион байгуулах боломжгүй, худалдан авах гэрээний эрх зүйн харилцааг олон улсын жишигт нийцүүлэх зохицуулалтыг цогц байдлаар тусгах, мөн гомдол шийдвэрлэх ажиллагааг олон улсын сайн туршлагад нийцүүлж, төр болон иргэний нийгмийн байгууллагын хамтын оролцоотойгоор олонхоор хэлэлцэн шийдвэрлэдэг тогтолцоог бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрсэн бөгөөд хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т заасны дагуу шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх зорилтыг тэргүүлэх чиглэл болгож 2.1.3.13-т “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжиж, худалдан авах бүтээгдэхүүний төсөвт өртгийг зах зээлийн үнэлгээнд нийцүүлнэ.”, 2.3.3.3-т “Эмийн худалдан авалтад үнийн хэлцэл хийх, олон

улсын байгууллагаар дамжуулан худалдан авах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авах тогтолцоог бүрдүүлнэ.”, 3.1.2.2-т “Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгож, хиймэл оюун ухааныг ашиглана.” гэж тус тус заасан бөгөөд бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд мега төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, уг төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бий зорилтыг дэвшүүлсэн.

Иймд Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог шинэчлэх үүргийг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад даалгасны дагуу Шадар сайдын 2024 оны 6 дугаар тушаалаар хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Сангийн яам, Хууль зүй, дотоодын хэргийн яам, Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Үндэсний аудитын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Монополын эсрэг газар, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, "Эрдэнэс Монгол" нэгдлийн төлөөллийг оруулан 18 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 42 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хуулийн төслийн хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах үүрэг бүхий ажлыг хэсгийн Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралаар ахлуулахаар шийдвэрлэсэн.

Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж тус хуулийг шинэчлэн найруулах шаардлагыг тодорхойлж энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг Шадар сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.

Хуулийн төслийн үзэл баримтлалын зорилгод тодорхойлсноор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг цаашид Худалдан авах ажиллагааны тухай хууль гэж нэрлэж /Шинэчилсэн найруулга/-ын төсөлд дараах үндсэн асуудлыг тусгасан:

1. Хуулийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх:

Хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зөвхөн Худалдан авах ажиллагааны тухай хуулиар зохицуулахаар тусгасан. Цаашид худалдан авах ажиллагааг зөвхөн хуулийн дагуу зохион байгуулна. Төсөл, арга хэмжээний онцлог, үүссэн нөхцөл байдал, төсөвт өртгөөс хамаарч тендер шалгаруулалтын арга сонгож худалдан авалтыг зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр хууль мөрдөхгүй асуудлыг нэг мөр

цэгцэлж, худалдан авах ажиллагаатай холбоотой тоо мэдээлэл нэгдсэн байдлаар төлөвлөх, тайлагнах боломжтой болно.

2. Худалдан авах ажиллагааны үр ашиг, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх:

Худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд чанар үнийн хосолмолоор гүйцэтгэгчийг сонгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг чанараар харьцуулж илүү чанартай барааг сонгох эрх зүйн орчныг бий болгосноор цаашид тендер шалгаруулалт дагасан олон сөрөг асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ. Нөгөө талаас оролцогч нарт тавигддаг шалгуурыг тухайн бараа, ажил, үйлчилгээтэй уялдуулан тодорхойлох, оролцогчид бус нийлүүлэх бараа, үйлчилгээ, гүйцэтгэх ажилд түлхүү анхаарах өөрчлөлтийг тусгалаа.

Сүүлийн жилүүдэд тендер шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжүүдийн тоо буурах, оролцогчгүй тендер шалгаруулалтын тоо өсөх хандлагатай байгаа бөгөөд 2024 онд нийт тендер шалгаруулалтын 44 хувь амжилтгүй болж, дахин зарласан статистик байна. Үүнд дүн шинжилгээ хийж өрсөлдөөнийг хязгаарладаг эрх зүйн зохицуулалтыг өөрчлөхөөр тусгалаа. 10 тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцоход баталгаа ирүүлэх шаардлагагүй бөгөөд баталгааны мэдэгдэл бөглөж тендер илгээх боломжтой болж байна. Мөн татвар, нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй гэж оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалздаг байсан зохицуулсан өөрчилж байна. Аливаа оролцогч тендер шалгаруулалтад оролцохд татвар, нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өр, төлбөртэй байж болох бөгөөд гагцхүү шалгарсан оролцогч худалдан авах гэрээ байгуулах үед холбогдох өр, төлбөрийг төлсөн байхаар өөрчилж байна. Ингэснээр оролцогчдын тоо бууруулдаг байдлыг хална.

3. Хиймэл оюун, технологийн дэвшлийг нэвтрүүлэх:

Техник технологийн хурдтай хөгжлийг дагаж худалдан авах ажиллагаанд нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Цаашид хиймэл оюуныг бараа, ажил, үйлчилгээний зах зээлийн судалгаа хийх, тендер нээх, тендерийг хянан үзэх, тендерийг үнэлэх, тендер шалгаруулалтын мэдээллийг ил болох, энэ хуульд заасан хураангуй жагсаалт үүсгэхэд ашиглах замаар худалдан авах ажиллагаанд хүний оролцоог бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

4. Шуурхай, хялбар тендер шалгаруулалт:

Мэдээллийн технологи, интернэтэд суурилсан тендер шалгаруулалтын аргуудыг шинээр хуулийн төсөлд тусгасан нь тендер шалгаруулалтыг аль болох богино хугацаанд зохион байгуулах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Худалдан авах ажиллагааны бүх үе шатыг цахим системд бүртгэж байгаа нь тендер шалгаруулалтын мэдээлэлтэй тендер оролцогч цаг алдалгүй танилцах боломжтой тул сонирхсон тендер эртнээс бэлдэх, орон зайн хязгаараас үл хамааран тендер илгээх боломжтой байхын зэрэгцээ төрийн мэдээллийн санд байгаа мэдээллийг харилцан солилцож, тендер шалгаруулалтын хянан үзэх шатны үнэлгээг цахим системээр хийх боломж бүрдэж шуурхай, хялбар тендер шалгаруулалт зохион байгуулах суурь нөхцөл болсон гэж үзэж байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааны бүх үе шатуудад тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн орчныг хуульд тусгаж өгснөөр тендер шалгаруулалтад

оролцогч талууд цахимаар мэдээлэл солилцох, харилцах боломжийг бүрдүүлсэн.

5. Эх оронч худалдан авалт:

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас санаачилсан дотоодын үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөдөлгөөн, хөтөлбөрүүдийг эх оронч худалдан авалтаар дэмжих зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийг дэмжиж одоогийн хуулийн сайн зохицуулалтуудыг бүрэн хадгалж давуу эрхийн зөрүү тооцох аргачлалыг боловсронгуй болголоо. Мөн дотоодын барааг импортын бараатай өрсөлдүүлэхгүй ба зөвхөн Монгол бараа үйлдвэрлэгч хоорондоо өрсөлдөнө. Засгийн газар чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж, чанартай, стандартад нийцсэн дотоодын барааг цахим дэлгүүрт байршуулж, төрийн байгууллагад тогтмол нийлүүлэх боломжийг хуулиар бий болгоно.

6. Мега төслийн худалдан авах ажиллагаа:

Хуулиар зохицуулсан тендер шалгаруулалтын аргууд нь төслийн хамрах хүрээ, төсөвт өртөг өндөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хангалтгүй байгаа тул мега төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, хэрэглэгддэг тендер шалгаруулалтын өөр аргуудыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага бий болсон байна. Монгол Улсын Их Хурлаас мега төслийн жагсаалтыг батална. Уг жагсаалтад багтсан төслийг гүйцэтгэгчийг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар сонгоно. Мега төслийн худалдан авах ажиллагааг олон улсад хэрэглэдэг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулна.

7. Маргаан шийдвэрлэх тогтолцоо:

Хуульд заасан маргаан шийдвэрлэх тогтолцоог өөрчилж байнгын ажиллагаатай зөвлөлийг байгуулахаар хуулийн төсөлд тусгалаа. Зөвлөлийн гишүүдийг худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага болон худалдааны танхимуудаас нийт 9 гишүүнийг санал болгож Засгийн газраас томилно. Уг зөвлөл нь тендер шалгаруулалттай холбоотой маргаан бие даан шийдвэрлэх бөгөөд ажлын албатай байхаар хуульд заасан. Тендер шалгаруулалттай холбогдох маргааныг шийдвэрлэх бие даасан бүтэц бий болно.

Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулан төрийн байгууллага, олон нийтээс санал авах, хуулийн төслийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, зардал тооцооны судалгааг тус тус хийж гүйцэтгэж байна.

Ажлын хэсэг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн өмчит компанийн нийт 54 төлөөлөл, “Монголын авто замчдын холбоо” ТББ, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо” ТББ, “Монголын Барилгын Зураг Төсөл Зохиогчдын Холбоо” ТББ, “Барилгын Төсөвчдийн Холбоо” ТББ, “Монголын Барилгын Инженер Геологичдын Холбоо” ТББ, “Өргөн Тээвэрлэх Машин Тоног Төхөөрөмжийн Үндэсний Холбоо” ТББ, “Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоо”

ТББ, “Монголын Бетоны Холбоо” ТББ, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ, “Монголын авто замчдын холбоо” ТББ, “Хуульчдын холбоо” ТББ-тай тус тус хамтран салбарын аж ахуйн нэгж байгууллага, төлөөллийг хамруулан тус тус зохион байгуулсан.

Төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоос өгсөн холбогдох саналыг тусган Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.

ЗАСГИЙН ГАЗАР